



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.08.16 № 04/51

ДЭЛГЭРХАНГАЙ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
О.БАТЧУЛУУН ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын үр дүнд нийцлийн аудит хийх явцад 40,585,975.00 /Дөчин сая таван зуун наян таван мянга есөн зуун далан таван/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 30,000,000.00 төгрөгийн төсөвт өртөгтэй “Инженерийн хийцтэй худаг” гаргах ажлын худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгохдоо босго үнийг мөрдөлгүй шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах /ТБОНӨХБАҮХА/ тухай хуулийн 8 дугаар зүйлийн, 8.1.-д /Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно/ 8.1.2-т /Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар/, 33 дугаар зүйлийн 33.1 –д /Бараа ажил үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно/, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралт /Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ/, хавсралтын 2–т /Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар нь бараа, ажлын хувьд – 10.0 сая/, гэж заасныг,

2. 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зураг, төсөв нь батлагдаагүй “Нэг цэгийн үйлчилгээний байрны халаалтын систем шинэчлэх” ажилд 10,585,975.00 төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д /Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана/, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 4.7-д /Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй/, 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай” журмын 6 дугаар зүйлийн 6.3.3.-т /Хөрөнгө,

1100500712

оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ хууль, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ Төсвийн тухай хууль, журмыг мөрдөж ажиллах.
3. **“Нэг цэгийн үйлчилгээний байрны халаалтын систем шинэчлэх”** ажлын холбогдох баримт бичгийн бүрдэл, техникийн тодорхойлолтод заасан ажлууд бүрэн хийгдсэн эсэхэд хяналт тавьж ажлыг хүлээн авсны дараа үлдэгдэл санхүүжилтийг олгох

Албан шаардлагын биелэлтийг 2017 оны 04 дүгээр сарын 25-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Дэлгэрхангай сумын Засаг дарга /О.Батчулуун/, засаг даргын орлогч /Ц.Батцэнгэл/, санхүүгийн албаны дарга /Ч.Батхуяг/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АХЛАХ ШИНЖЭЭЧ

Д.ИХБАЯР

ЗАСАГ ДАРГА

О.БАТЧУЛУУН

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Ц.БАТЦЭНГЭЛ

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА

Ч.БАТХУЯГ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.